



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар A/329

Хэрлэн сум

Гр.                   Өрхийн мэдээллийн судалгааг  
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 тоот хамтарсан тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох, мэдээлэл цуглуулах ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:                   Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Нарийн бичгийн

дарга:                   Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга

Гишүүд:

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Цагдаагийн газрын дарга

2.Сумдад өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулахыг сумын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3.Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох мэдээлэл цуглуулах ажлыг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 964 өрхийг хамруулан 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн хугацаанд зохион байгуулж, харьяа дээд байгууллагад заасан хугацаанд тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

